



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ



7053-3552



www.audit.mn



umnugovi@audit.mn



2025 ОН



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/42

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9 дэх заалт, 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхийг Ахлах аудитор (С.Одончимэг)-т даалгасугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор (Н.Хулан)-д үүрэг болгосугай.



Ц.ӨСӨХБАЯР

4625010102

Гарчиг

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	1
Аудитын зорилго	1
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	1
Аудитын хамарсан хүрээ.....	1
Талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
Аудитын бүрэлдэхүүн.....	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	2
НЭГ. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 2026 ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД БАТЛААГҮЙ ТУЛ 2026 ОНЫ ТӨСВИЙГ АЙМАГ ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ЭСЭХЭД ДҮГНЭЛТ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.	3
ХОЁР. ТӨСВИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ СУДАЛЖ ТУСГААГҮЙ НЬ ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ ЭРСДЛИЙГ ҮҮСГЭЖ БАЙНА.	4
ГУРАВ. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ХУУЛЬ, ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН БОДИТОЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	10
ДӨРӨВ. ТӨСВИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	18
ДҮГНЭЛТ	20
ЗӨВЛӨМЖ.....	21

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.
Аудитын зорилго	Аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр, боловсруулж, төрийн санхүүгийн удирдлага сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэн доорх асуултад хариулт өгөхөд аудитын зорилго чиглэсэн. Үүнд: Төсвийн санхүүжилтийг бодлогын баримт бичигтэй уялдуулж, хууль эрхзүйн хүрээнд боловсруулсан эсэх Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төлөвлөж, орлого нэмэгдүүлэх боломжийг судалж, тусгасан эсэх Орон нутгийн төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөн, зарлага бууруулах, хэмнэх боломжийг тусгасан эсэх Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлсэн эсэх
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын явцад АДБОУС, Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аргачлал” аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, гарын авлагыг мөрдөж ажиллав.
Аудитын хамарсан хүрээ	Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан. Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан шаардлагыг гол шалгуур болголоо. Аудитад аймгийн 2026 оны төсвийн төсөл, бүх шатны төсөв захирагчид болон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэв.
Талуудын хүлээх үүрэг, хариуцлага	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-т заасны дагуу аймгийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй. Төрийн аудитын байгууллага нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасны дагуу аймгийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.
Аудитын бүрэлдэхүүн	Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижиболд, Ж.Болормаа, С.Одончимэг, аудитор Э.Жаргал, Т.Хишигбат, Ө.Болортуяа,

П.Санчиргарав, М.Номиндарь, Т.Будсүрэн, О.Чойдорж, А.Ганзуузай,
Н.Хулан нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл арга хэмжээ

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сангийн яамны хянасан орлого болон аймгийн төсвийн орлогын санал	4
Хүснэгт 2. Аймгийн 2025 оны төсвийн орлого ба хүлээгдэж буй гүйцэтгэл.....	5
Хүснэгт 3. Тавантолгой ХК-ийн үндсэн үйлдвэрлэлийн мэдээлэл.....	8
Хүснэгт 4. Татварын өрийн үлдэгдэл өссөн дүнгээр	9
Хүснэгт 5. Сангийн яамны хянасан хязгаар болон төсвийн төслийн зарлагын харьцуулалт (сая төгрөг).....	10
Хүснэгт 6. ТАХ-ын ерөнхий мэдээлэл (сая төгрөг).....	12
Хүснэгт 7. Зураг, төсөвгүй барилга, байгууламж (сая төгрөг).....	13
Хүснэгт 8. Шинээр авахаар төлөвлөсөн авто машины судалгаа (сая төгрөг).....	14
Хүснэгт 9. Журамд нийцээгүй төсөл арга хэмжээ (сая.төгрөг).....	15
Хүснэгт 10. Журамд нийцээгүй төсөл арга хэмжээ (сая.төгрөг).....	16
Хүснэгт 11. Урьдчилсан тооцоололгүй төсөл арга хэмжээ (сая.төгрөг).....	16
Хүснэгт 12. Зорилтот түвшин ижил болон бууруулж төлөвлөсөн зарим хөтөлбөр	18

НЭГ. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 2026 ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД БАТЛААГҮЙ ТУЛ 2026 ОНЫ ТӨСВИЙГ АЙМАГ ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ЭСЭХЭД ДҮГНЭЛТ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

1.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-т “орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх ...” гэж заасан байдаг.

1.2 Өмнөговь аймгийн 2026 хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд батлаагүй тул аймгийн 2026 оны төсвийн төслийг хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.

1.3 Мөн 2026-2030 онд баримтлах таван жилийн үндсэн чиглэл батлагдаагүй тул аймгийн 2026 оны төсвийн төслийг дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэхэд дүгнэлт гаргах боломжгүй байна.

1.4 Дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлаагүй байгаа нь төсвийн төслийг боловсруулахдаа хөгжлийн бодлогын баримт бичгийн нийцлийг бүрэн хангахгүй, төсөл, арга хэмжээнүүд зорилтот үр дүндээ хүрэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

ТӨСВИЙН ТӨСЛИЙН ИЖ БҮРЭН, ҮНЭН ЗӨВ БАЙДЛЫГ ХАНГАЖ ИРҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1.5 Төсвийн тухай хуулийн 5-д¹ ил тод, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг хэрэгжүүлэхээр заасан байдаг.

1.6 Гэвч орон нутгийн 2026 оны төсвийн санал асуулгыг 10 хоногийн хугацаанд цахимаар авч нийт 526 иргэн хамруулсан боловч иргэдийн өгсөн саналыг төсвийн төсөлд тусгасан эсэх талаар нэгтгэн дүгнэсэн, мэдээлэл байхгүй байна.

1.7 Төсвийн санал асуулгаар үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх талаарх төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал болон төрийн албан хаагчдын гадаад томилолт, спортын уралдаан тэмцээн, гадаад аялал, улс, бүсийн зөвлөгөөн, иргэдэд төсвөөс олгож байгаа тэтгэмж, гарын бэлэг тараах гэх мэт үр ашиггүй зардлыг бууруулах саналууд гарсан байна.

1.8 Олон нийтийн санал асуулгын үр дүнг төсвийн төсөл боловсруулахдаа анхаарч үзэх нь зүйтэй.

1.9 Аймгийн 2026 оны төсвийн төслийг ирүүлэхдээ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.1² дэх хэсгийн 7.1.5 дахь заалтын шаардлагыг хангаагүй.

1.10 Цаашид тухайн жилийн төсвийн төслийг хууль, журамд заасан зарчмыг баримтлан, шаардлагыг хангуулж Төсвийн тухай хуулийн 33.2-т заасны дагуу боловсруулж, мөн хуулийн 67.2 дахь заалтыг хэрэгжүүлж төсвийг иж бүрэн, үнэн зөв байдлыг хангаж байх шаардлагатай байна.

Аймгийн үнэт цаас гаргаж, нийт өрийн үйлчилгээний төлбөрийг 2026-2030 оны хооронд төлж барагдуулахаар урьдчилан төлөвлөсөн нь өрийн болон эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх шаардлагыг үүсгэж байна.

1.11 Ирэх онуудын төсвийн орлогын хэмжээг эдийн засгийн нөхцөл байдал, уул уурхайн салбарын түүхий эдийн үнийн хэлбэлзэл, нүүрсний экспорт зэрэгтэй уялдуулан, үндэслэлтэй тооцож, хүүгийн хэмжээ болон эргэн төлөлтийн тооцооллыг Өрийн удирдлагын тухай хуулийн 6.3.3³, 6.6.3⁴, Төрийн

¹ Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

² 7.1.Орон нутгийн жилийн төсвийн төсөл нь дараах шаардлагыг хангасан байна: 7.1.1.үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх; 7.1.2.төсвийн тэнцэл алдагдалгүй байх; 7.1.3.хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх; 7.1.4.эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх; 7.1.5.худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.

³ /6.3.3.Засгийн газар болон орон нутгийн зээллэг, Засгийн газрын өрийн баталгаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр нөлөө нь ирээдүйд өрийн дарамт учруулахгүй байх;/

⁴ /6.6.3.энэ хуульд заасны дагуу өр үүсгэж байгаа аливаа этгээд нь өр төлбөрийн үүргээ хууль болон гэрээнд заасны дагуу хугацаанд нь төлж барагдуулах, санхүүгийн хариуцлагатай байх;/

хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5⁵-д заасны дагуу төсөвт хүндрэл, өрийн дарамт учруулахгүй, хуваарийн дагуу төлж барагдуулах боломжтой байхаар төлөвлөх нь зүйтэй байна.

1.12 Үнэт цаасны эргэн төлөх үндсэн болон хүүгийн төлбөрийг 2028 онд 214.0 тэрбум, 2029 онд 332.0 тэрбум төгрөг байхаар урьдчилан тооцоолсон байгаа нь тухайн жилийн төсөвт нөлөөлөх ачааллыг нэмэгдүүлэх, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх болон тулгамдсан асуудлаа орон нутаг бие даан шийдвэрлэх боломжгүй болох эрсдэлийг бий болгож байна.

ХОЁР. ТӨСВИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ СУДАЛЖ ТУСГААГҮЙ НЬ ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ ЭРСДЭЛИЙГ ҮҮСГЭЖ БАЙНА.

2.1 Ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн орлогыг жилийн төсвийн хязгаар, аймгийн төсвийн орлогын 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөвлөжээ.

2.2 Тухайн шатны төсөвт орох татварын болон татварын бус орлогыг доод хувь, хэмжээгээр тооцсон орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас 1,593,752.0 сая төгрөг байхаар хянасан байна.

2.3 Үүнээс Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд заасны дагуу 71.7 хувь буюу 1,143,259.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

2.4 Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2026 оны аймаг, сумдын төсвийн орлогыг 1,895,708.3 сая төгрөг байхаар тооцож төсвийн суурь орлогыг 301,956.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Сангийн яамны хянасан орлого болон аймгийн төсвийн орлогын санал

Төсвийн орлого эдийн засгийн ангиллаар	Сангийн яам хянасан 2026 оны суурь орлого	Аймгийн 2026 оны төсвийн орлогын санал	Зөрүү +/-
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,593,752.0	1,895,708.3	301,956.3
ТАТВАРЫН ОРЛОГО	1,488,745.2	1,779,034.1	290,288.9
Орлогын албан татвар	1,173,700.0	1,456,069.4	282,369.4
Хувь хүний орлогын албан татвар	264,200.0	264,200.0	-
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	246,000.0	246,000.0	-
Үйл ажиллагааны орлого	1,500.0	1,500.0	-
Хөрөнгийн орлого	3,100.0	3,100.0	-
Хөрөнгө борлуулсны орлого	1,600.0	1,600.0	-
Шууд бус орлого	12,000.0	12,000.0	-
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,600.0)	(2,600.0)	-
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,600.0)	(2,600.0)	-
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /40 хувь/	912,100.0	1,194,469.4	282,369.4
Хөрөнгийн албан татвар	270,350.0	277,050.0	6,700.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	260,000.0	260,000.0	-
Бууны албан татвар	50.0	50.0	-
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	10,300.0	17,000.0	6,700.0
Бусад татвар төлбөр хураамж	44,695.2	45,914.7	1,219.5
Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,202.0	4,202.0	-
Улсын тэмдэгтийн хураамж	1,920.0	1,920.0	-
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,532.0	1,532.0	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	750.0	750.0	-

⁵ /15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;/

Газрын төлбөр	13,195.3	14,100.0	904.7
Газрын төлбөр	13,195.3	14,100.0	904.7
Байгалийн нөөц ашигласны төлбөр	27,297.9	27,612.7	314.9
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр	601.4	616.3	14.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	26,696.4	26,696.4	-
Бусад татвар	-	300.0	300.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104,926.8	116,594.2	11,667.4
Нийтлэг татварын бус орлого	104,926.8	116,594.2	11,667.4
Хувьцааны ногдол ашиг	95,000.0	95,000.0	-
Хүүгийн орлого	316.8	-	316.8
Торгуулийн орлого	8,000.0	8,081.2	81.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого	69.0	11,972.0	11,903.0
Түрээсийн орлого	100.0	100.0	-
Газрын тосны орлого	241.0	241.0	-
Бусад орлого	1,200.0	1,200.0	-
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	80.0	80.0	-
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	80.0	80.0	-

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.5 Монгол Улсын Сангийн сайдаас аймгийн Засаг дарга нарт орон нутгийн 2026 оны төсвийн орлогын төлөвлөлт, орлогын гүйцэтгэлийг сайжруулах талаар ирүүлсэн чиглэлд ирэх оны төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд суурилах үндэслэлгүйгээр нэмэгдүүлэхгүй байх, Сангийн яам хянасан орлогын дүнтэй уялдуулах гэж тусгажээ.

2.6 ТЭЗ-аас төсвийн орлогын төслийн танилцуулга, мэдээлэл, төсөвт төвлөрүүлэх орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогын тооцоолол, судалгаа, холбогдох баримтыг ирүүлээгүй байна.

2.7 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Аймгийн 2025 оны төсвийн орлого ба хүлээгдэж буй гүйцэтгэл

Төсвийн орлого эдийн засгийн ангиллаар	2025 оны баталсан төсвийн орлого	2025 оны 10 сарын 30-ны орлогын гүйцэтгэл	2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,965,130.0	1,294,757.7	1,733,479.3	88.2
ТАТВАРЫН ОРЛОГО	1,754,538.3	1,109,420.6	1,516,560.5	86.4
Орлогын албан татвар	1,459,260.3	873,161.2	1,227,020.3	84.1
Хувь хүний орлогын албан татвар	278,440.0	239,249.1	279,337.8	100.3
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	262,520.0	224,949.2	261,907.8	99.8
Үйл ажиллагааны орлого	1,050.0	1,080.0	1,136.2	108.2
Хөрөнгийн орлого	3,540.0	2,609.0	2,986.8	84.4
Хөрөнгө борлуулсны орлого	830.0	954.6	957.3	115.3
Шууд бус орлого	10,500.0	9,656.4	12,349.7	117.6
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,317.4)	(2,317.4)	(2,317.4)	100.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,317.4)	(2,317.4)	(2,317.4)	100.0
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /40 хувь/	1,183,137.8	636,229.4	950,000.0	80.3
Хөрөнгийн албан татвар	240,929.0	192,668.0	242,081.2	100.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	227,864.0	180,552.9	227,793.0	100.0
Бууны албан татвар	45.0	39.2	44.6	99.0
Малын тоо толгойн албан татвар	-	601.1	727.2	

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	13,020.0	11,474.8	13,516.4	103.8
Бусад татвар төлбөр хураамж	54,349.0	43,591.4	47,459.0	87.3
Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,730.0	4,396.0	4,586.2	168.0
Улсын тэмдэгтийн хураамж	680.0	1,483.1	1,593.8	234.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,500.0	2,415.4	2,416.2	161.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	550.0	497.4	576.2	104.8
Газрын төлбөр	13,965.0	13,054.4	13,945.6	99.9
Газрын төлбөр	13,965.0	13,054.4	13,945.6	99.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	37,654.0	26,141.1	28,927.2	76.8
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	95.0	100.8	
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр	454.0	562.7	601.3	132.4
Үйлдвэр үйлчилгээний усны төлбөр	36,900.0	25,095.4	27,834.1	75.4
Бусад татвар / зам ашигласны хураамж /	300.0	387.9	391.0	130.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,470.4	185,215.1	216,742.6	103.0
Нийтлэг татварын бус орлого	210,470.4	185,215.1	216,742.6	103.0
Хувьцааны ногдол ашиг	186,940.4	156,940.7	186,940.7	100.0
Торгуулийн орлого	11,281.2	21,136.1	21,430.9	190.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,867.4	6,095.9	6,982.3	64.3
Түрээсийн орлого	131.0	57.4	100.7	76.9
Газрын тосны орлого	100.4	-	100.4	100.0
Бусад нэр заагдаагүй орлого	1,150.0	985.0	1,187.6	103.3
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	121.3	122.0	176.2	145.3
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	121.3	122.0	176.2	145.3

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

2.8 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 2025 оны 10 дугаар сарын байдлаар 65.9 хувьтай, хүлээгдэж буй гүйцэтгэлийг 1,733,479.3 сая төгрөг байхаар тооцсон нь 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө биелэх боломжгүйг харуулж байна.

2.9 Аймаг, сумдын төсвийн орлогыг өмнөх оны тодотгосон төсвөөс нийт дүнгээр 69,421.7 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн нь хувьцааны ногдол ашгийн төлөвлөлттэй холбоотой байна.

ТАТВАРЫН ОРЛОГЫН ТАЛААР:

ТАТВАРЫН ОРЛОГЫГ НЭР ТӨРЛӨӨР БОДИТОЙ ТООЦОЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ НЬ ОРЛОГО ТАСРАХ ЭРСДЭЛ ДАГУУЛЖ БАЙНА.

2.10 Татварын орлогыг Сангийн яам хянасан дүнгээс 290,288.9 сая төгрөгөөр буюу 19.5 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

2.11 Аж ахуй нэгжийн орлогын албан татварын 40 хувийн хуваарилалтын орлогыг 282,369.4 сая төгрөгөөр бодит тооцоо судалгаа, орлогын гүйцэтгэлтэй уялдуулаагүй, нэмэгдүүлэн төлөвлөсөн нь орлого тасрах эрсдэлийг дагуулж байна.

2.12 Хувь хүний орлогын албан татварыг өмнөх оноос 16,520.0 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн нь Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасан төрийн албаны бүтцийг тэлэхгүй байх, төрийн албыг цомхон, давхардалгүй, чадварлаг бүтцээр ажиллуулах, МУЗГ-аас багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь бууруулах бодлого хэрэгжүүлж байгаатай холбоотой байна.

2.13 Үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, шууд бус орлогыг гүйцэтгэлийг үндэслэн нийт 14.3 хувиар нэмэгдүүлэн Сангийн яам хянасан дүнгээр төлөвлөсөн байна.

2.14 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг Сангийн яам хянасан дүнгээс 6,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч

хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, 3⁶ дахь хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас "Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хувь хэмжээ"-г шинэчлэн нэмэгдүүлж тогтоосонтой холбоотой байна.

2.15 Аудитаар аймгийн татварын газрын ирүүлсэн тээврийн хэрэгслийн тоо мэдээлэлд үндэслэн Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг 617.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх боломжтой байна. (Хавсралт №1)

2.16 Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг өмнөх оноос 32,136.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн Сангийн яам хянасан дүнгээр төлөвлөсөн байна. Аймгийн татварын газарт бүртгэлтэй татвар төлөгчийн тоо 1142, үл хөдлөх хөрөнгийн тоо 2298 байгаа бөгөөд тооцоо судалгаанд үндэслээгүй төлөвлөсөн байна.

2.17 Малын тоо толгойн албан татварын орлогыг сумдын төсвийн суурь орлогод төлөвлөөгүй байна. Энэ нь орон нутгийн онцлог, ган зуд, малчдын амьжиргаатай уялдуулан жил бүр сумын ИТХ-аар өөрчлөн тогтоож байгаагаар холбоотой байна.

2.18 Бусад нийтлэг төлбөр, хураамжийн орлогын хувьд өмнөх оноос 53.9 хувиар нэмэгдүүлэн 4,202.0 сая төгрөгөөр Сангийн яам хянасан дүнгээр төлөвлөсөн нь 2025 оны орлогын гүйцэтгэлээр биелэх боломжтой байна.

2.19 Засгийн газрын 2023 оны 463 дугаар тогтоолоор баталсан "Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам"-ын 5.3-д *"Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, ээлжит засвар, арчлалтын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр тооцох борлуулалтын үнэлгээ нь нэг шоо метр тутамд 1 төгрөг байна"* гэж заасны дагуу орон нутагт хийгдэж байгаа хатуу хучилттай зам барих ажилд ашиглагдаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг өмнөх оноос нэмэгдүүлж төлөвлөөгүй байна.

2.20 Ус, рашаан ашигласны төлбөрийг сумдын суурь орлогод тооцож төлөвлөөгүй байх бөгөөд гүйцэтгэлээр 90.6 сая төгрөг төвлөрсөн байна.

2.21 Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийг өмнөх оноос 162.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн Сангийн яам хянасан дүн болон Байгаль орчны яам, Байгаль орчны газраас ирүүлсэн дүн мэдээлэлд үндэслэн төлөвлөсөн байна.

2.22 Газрын төлбөрийг Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/6 дугаар тогтоолоор баталсан "Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээ"-г үндэслэн газрын нэгдсэн санд бүртгэгдсэн нэгж талбар, талбайд ногдох суурь үнэлгээг тооцож 14,075.3 сая төгрөгөөр тооцож хүргүүлснийг Сангийн яам 14,100.0 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

2.23 Үйлдвэр, үйлчилгээний усны төлбөрийг өмнөх оны тодотгосон төсвөөс 10,203.6 сая төгрөгөөр бууруулан Сангийн яам хянасан дүнгээр төлөвлөсөн нь гүйцэтгэлд үндэслэсэн, биелэх боломжтой байна.

2.24 Авто замын тухай хуулийн 30.1⁷ дэх хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас "Авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хэмжээ"-г шинэчлэн нэмэгдүүлэн баталсан байна.

2.25 Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг 300.0 сая төгрөг байхаар бусад татвар хэсэгт тусгасан байна.

2.26 Аудитаар аймгийн татварын газарт бүртгэлтэй автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн тоонд авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг ногдуулахад 1,714.5 сая төгрөгөөр төсвийн орлого нэмэгдэх боломжтой гэж тооцож байна. (Хавсралт №2)

⁶ Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан албан татвар төлөгчийн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэлтэй аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.

⁷ Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замын урт, төлбөрийн хэмжээг Засгийн газар, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замын урт, төлбөрийн хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.

2.27 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5, 7 дугаар зүйлийн 7.1, 7.4-т заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 4/29 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа агаар бохирдуулагчаар төлүүлэх “Агаарын бохирдлын төлбөрийн хувь хэмжээ”-г баталсан байна.

2.28 Дээрх төлбөр нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.12⁸-д заасны дагуу аймгийн төсвийн орлого болох бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс хэрэгжихээр хуульд тусгасан ч Сангийн яамнаас орон нутгийн суурь орлогод тооцоогүй байна.

2.29 Гэсэн хэдий ч орон нутгийн онцлог, боломжийг ашиглан уул уурхайн компаниудын олборлосон түүхий нүүрсний килограмм тутамд 2 төгрөгийн төлбөр ногдуулахад 2026 оны сүүлийн хагас жилд агаарын бохирдлын төлбөрөөр төсөвт 27,172.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжтой байна. (Хавсралт №3)

2.30 Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжих эхэлснээр аймгийн төсвийн орлогод “Хотын албан татвар”-ыг төлөвлөж татварын хувийг байршил, хүн амын төвлөрлийг харгалзан 0-2.0 хувийн хязгаарт багтаан эрх бүхий байгууллагаас тогтоож төсвийн орлогоо нэмэгдүүлэх нь зүйтэй.

ТАТВАРЫН БУС ОРЛОГЫН ТАЛААР:

ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ СУДАЛЖ ТУСГААГҮЙ БАЙНА.

2.31 Сангийн яамнаас татварын бус орлогыг 104,926.8 сая төгрөгөөр хянасныг 116,594.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь төсөвт байгууллагын өөрийн орлогыг 11,972.0 сая төгрөгөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

2.32 Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд татварын бус орлогыг өмнөх оноос 93,876.2 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн нь орон нутгийн өмчит Тавантолгой ХК-ийн ашгаас орон нутагт ногдох хувьцааны ногдол ашигтай холбоотой байна.

2.33 Тавантолгой ХК-ийн үндсэн үйлдвэрлэлийн мэдээлэл 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлангаар дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Тавантолгой ХК-ийн үндсэн үйлдвэрлэлийн мэдээлэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он	2024 он	2025 оны хагас жил	Өөрчлөлт 2024/2025
Хөрс хуулалт	мян.м3	5,590.0	11,860.0	1,219.1	-89.7%
Нүүрс олборлолт	мян.тн	690.0	2,330.0	40.6	-98.3%
Уулын цул	мян.м3	6,080.0	13,980.0	1,248.1	-91.1%

Эх сурвалж: Тавантолгой ХК-ий 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

2.34 Тус компани нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дагуу 2025 оны эхний хагас жилд Монголын хөрөнгийн биржийн нээлттэй цахим арилжаагаар 454,400 тонн 39,667,200 ам.долларын нүүрс арилжсан байна.

2.35 Нүүрсийг биржээр дамжуулан борлуулах нь зах зээлийн ил тод байдал, үнэ тогтоох механизмд томоохон нөлөө үзүүлж байгаа хэдий ч биржийн шимтгэл, үйлчилгээний төлбөр нэмэгдсэн байна.

2.36 Сангийн яамнаас хувьцааны ногдол ашгийг 95,000.0 сая төгрөгөөр хянасныг аймгийн төсвийн орлогын саналд тусгаж ирүүлсэн бөгөөд дээрх нөхцөл байдлаас шалтгаалан уг орлого тасрах эрсдэл өндөр байгааг анхаарах нь зүйтэй.

2.37 Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого төвлөрүүлэгч байгууллагуудын санал, төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл, эх үүсвэрийг бодитой тодорхойлоогүй өмнөх оноос 3,200.0 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

2.38 Төсөвт байгууллагын өөрийн орлогод 11,972.0 сая төгрөг тооцож төлөвлөснөөс 43.8 хувийг ОНТХО-ын авлагаас, 41.7 хувийг ОНХС-ийн хандивын орлогоор бүрдүүлнэ гэж тооцжээ.

⁸ Агаарын бохирдлын төлбөр

2.39 ОНТХО-ын авлагад олон жил дамжсан шинэ мянган айл орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлсэн 4 аж ахуй нэгжийн 3,965.5 сая, махны нөөцийн үйлдвэрийн 70.0 сая, иргэн хувь хүнээс авах 37.1 сая төгрөг болон шинээр сүү, шохойн чулуу, асфальтны үйлдвэр байгуулах төсөлд оруулсан хөрөнгийн эргэн төлөлтийн 1,184.4 сая төгрөгийн үлдэгдэл тус тус байна.

2.40 ОНХС-ийн хандивын орлогоор 5,000.0 сая төгрөг төлөвлөсөн нь Эрдэнэс Тавантолгой ХК-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу төвлөрөх хандивын орлого байна.

2.41 Өмнөговь аймгийн газар нутагт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагуудтай Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1⁹-д заасныг гэрээнд тусгаснаар хандив тусламжийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

2.42 Түрээсийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 31.0 сая төгрөгөөр бууруулан 100.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг аймгийн ИТХ-ын 2022 оны 6/18 дугаар тогтоолоор баталсан жишиг үнээр тооцсон байна.

2.43 Орон нутгийн өмчийн хөрөнгийн түрээсийн доод үнийг орон нутгийн онцлог болон зах зээлийн жишиг үнэтэй уялдуулан шинэчлэн тогтоосноор түрээсийн орлого нэмэгдэх боломжтой байна.

2.44 Газрын тосны орлогыг Сангийн яам хянасан дүнгээр шинээр төлөвлөсөн бол бусад орлого, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг Сангийн яамны хянасан дүнгээр төлөвлөсөн байна.

2.45 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах, бааз суурийг өргөтгөх, татвар төлөгчийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэх, ажил гүйлгээг бүртгэлжүүлэх үйл ажиллагааг сайжруулахад орон нутгийн зүгээс ач холбогдол өгч ажиллаж байгаа хэдий ч татварын өрийн үлдэгдэл буураагүй нэмэгдсээр байна.

2.46 Аймгийн Татварын газраас ирүүлсэн мэдээлэлд татварын өрийн үлдэгдэл 2025 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар 133,652.6 сая төгрөг байна. Үүний 63.0 хувь буюу 84,305.7 сая төгрөг нь татвар төлөгчдөд татварын хяналт шалгалтаар ногдуулсан татварын торгууль, алдангийн төлөгдөөгүй өрийн үлдэгдэл байна.

Хүснэгт 4. Татварын өрийн үлдэгдэл өссөн дүнгээр

№	Татварын төрөл	Өр дүн /сая төгрөг/
1	Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	4,675.0
2	Газрын төлбөр	3,382.4
3	Газрын үл хөдлөх хөрөнгийн албан татвар	48.7
4	Галт зэвсгийн албан татвар	13.4
5	Малын тоо толгойн албан татвар	1,385.0
6	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	3,399.4
7	Хувь хүний орлогын албан татвар	2,078.3
8	Хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	10,357.9
9	Цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос суутгасан татвар	23,767.7
10	Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар	164.3
11	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	74.8
12	Татварын торгууль, алданги	84,305.7
	Нийт дүн	133,652.6

Эх сурвалж: Аймгийн Татварын газар

2.47 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл, татварын өрийг барагдуулснаар төсвийн орлого нэмэгдэх боломжтой байна.

⁹ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана

ГУРАВ. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ХУУЛЬ, ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН БОДИТОЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1 Монгол Улсын Сангийн сайдаас аймгийн Засаг дарга нарт орон нутгийн 2026 оны төсвийн орлогын төлөвлөлт, орлогын гүйцэтгэлийг сайжруулах талаар ирүүлсэн чиглэлд байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийн, бүтэц зохион байгуулалтын оновчтой хувилбарыг сонгож, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулахыг чиглэл болгосон хэдий ч зарим байгууллагууд баримтлаагүй байна.

Хүснэгт 5. Сангийн яамны хянасан хязгаар болон төсвийн төслийн зарлагын харьцуулалт (сая төгрөг)

№	Зарлага	СЯ-наас хянасан хязгаар	2026 оны төсвийн санал	Зөрүү дүн
3.1.1	Аймгийн ИТХ	3,866.4	3,807.4	(58.9)
3.2.1.1	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	45,865.6	23,561.5	(22,304.1)
3.2.1.2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	4,675.6	14,422.3	9,746.7
3.2.1.3	Орон нутгийн өмчийн газар	453.0	1,187.0	734.0
3.2.1.4	Худалдан авах ажиллагааны газар	318.5	646.3	327.8
3.2.1.5	Байгаль орчны газар	934.8	2,020.9	1,086.1
3.2.1.6	Ахмадын холбоо	110.6	266.8	156.1
3.2.1.7	Засаг дарга ерөнхий данс /хөтөлбөр/	366.0	144,997.4	144,631.4
3.2.1.8	Ойн анги	311.9	2,055.8	1,743.9
3.2.1.9	Санхүүгийн хяналт, аудитын алба	424.1	495.3	71.2
3.2.1.10	Олон нийтийн цагдаагийн алба	-	582.3	582.3
3.2.1.11	Халамжийн сан	163.9	186.1	22.2
3.2.1.12	Буянт хотхон	-	2,092.9	2,092.9
3.2.1.13	Мал хамгаалах сан	255.3	1,000.0	744.7
3.2.1.14	Байгаль хамгаалах сан	11,083.4	3,000.0	(8,083.4)
3.2.1.15	Музейн байр ашиглалтын зардал	-	539.2	539.2
3.2.1.16	ХЖТеатрын байр ашиглалтын зардал	-	800.0	800.0
3.2.1.17	Номын сангийн байр ашиглалтын зардал	-	488.2	488.2
3.2.1.18	БТСГазрын байр ашиглалтын зардал	518.4	836.4	317.9
3.2.1.19	Политехникийн коллежийн байр ашиглалтын зардал	299.4	881.8	582.3
3.2.1.20	Насан туршийн боловсролын төв	-	37.0	37.0
3.2.1.21	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	3,368.1	2,914.7	(453.3)
3.2.1.22	Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар	1,880.0	3,702.6	1,822.5
3.2.1.23	Төслийн нэгдсэн удирдлагын газар	-	2,925.7	2,925.7
3.2.1.24	Төрийн архивын хэлтэс	-	888.7	888.7
Дүн		74,895.6	214,337.3	139,441.8

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

3.2 Аймгийн 2025 оны төсвийн хязгаарын саналыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан “Төсвийн удирдлагын зарчим”-д заасантай нийцээгүй гэж үзэж орон нутгийн төсвийн суурь зарлагыг хянахдаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, төрийн үйлчилгээний салбарт ажиллагсдын тоо, орон нутгийн төр захиргааны байгууллагуудын тоо, уур амьсгалын өөрчлөлт зэрэг бусад хүчин зүйлийг харгалзан үзэх талаар Сангийн яаманд санал хүргүүлсэн ч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

3.3 Иймээс орон нутаг өөрийгөө санхүүжүүлэх урсгал зардал хүрэлцэхгүй, төрийн ажил, үйлчилгээ тасрах, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэхгүй байх эрсдэлээс сэргийлэн Сангийн яамны хянасан суурь зарлагыг нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

3.4 Гэсэн ч зарим байгууллагуудын урсгал зардлыг Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдүүлэн төлөвлөж тэвчиж болох зардлуудыг бууруулаагүй байна.

3.5 Аймгийн 2026 оны төсвийн төсөлд төсөвлөлтийн шаардлага хангаагүй дараах урсгал зарлагыг тусгасан байна. Үүнд:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал Засгийн газрын 2021 оны “Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай” 376 дугаар тогтоолд орон тоог 10 хүртэл байхаар тогтоосон хэдий ч 2026 оны төсвийн төслийн саналд 14 орон тоотой байхаар төсөвлөсөн байна.
- Засгийн газрын 2025 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” 37 дугаар тогтоолд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тоог 55 хүртэл байхаар тогтоосныг 67 орон тоотой байхаар төсөвлөсөн нь төрийн албаны бүтцийг тэлэхгүй байх, төрийн албыг цомхон, давхардалгүй, чадварлаг бүтцээр ажиллуулах Засгийн газрын бодлого шийдвэртэй нийцэхгүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардалд байгаль хамгаалагч нарын нормын хувцас авахад зориулж 100.0 сая, Байгаль орчны газрын урсгал зардалд мөн 22.0 сая төгрөгийг давхардуулан төлөвлөсөн байна.
- Олон нийтийн цагдаагийн албаны цалингийн зардал 1,007.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардалд төлөвлөсөн байна.

3.6 “Өмнөговь аймгийн төслийн нэгдсэн удирдлагын газар” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 2,925.7 сая төгрөг төсөвлөсөн байна.

3.7 Аймгийн ИТХ-ын 2025 оны 7/06 дугаар тогтоолоор байгуулсан “Өмнөговь аймгийн төслийн нэгдсэн удирдлагын газар” **орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын ангилал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйл “Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт, ангилал”, улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээдийн хэлбэр нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд “Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд”** заасантай тус тус нийцэхгүй байна.

3.8 Мөн Аймгийн ИТХ-ын дээрх тогтоолоор баталсан тус газрын дүрмийн 2.3-д “Газар нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ”, 3.2-д “...төсвийг аймгийн Засаг дарга аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ”, 4.4.2-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хариуцлагатай зарцуулах”, 5.1-д “Газрын санхүүгийн эх үүсвэр нь улс, орон нутгийн төсвийн санхүүжилт” заасан **эд хөрөнгийн эрхийн байдал нь** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ” заасан **“төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын төсөвт үйлдвэрийн газар”** ангилалд хамаарч байх бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр нь тус хуулийн 22 дугаар зүйлийг “Төрийн өмчит үйлдвэрийн газар ба албан газрыг Засгийн газрын буюу хуулиар тусгайлан олгосон эрх бүхий байгууллагын шийдвэрээр байгуулах...” зөрчсөн байна.

3.9 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан “Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд”¹⁰, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2¹¹, Монгол улсын Ерөнхий сайдын Монгол улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг мөрдөж, төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг өндөржүүлэн, ажлын бүтээмжийг сайжруулах зорилго бүхий “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 албан даалгавар¹², Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2¹³, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

¹⁰ 7.1 Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ:

¹¹ 15.1.2 Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох;

¹² 1.3 Яам харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх

¹³ 2. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12¹⁴-д заасныг баримталж төсвийг хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөх шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засвар, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн талаар:

3.10 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2026 онд барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ-д нийт 313 төсөл, арга хэмжээнд 411,399.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

3.11 Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 2.3.2.1-д орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнахаар заасан.

3.12 Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг эрэмбэлсэн байдлын авч үзэхэд дээрх журамд заасан шалгуур үзүүлэлт, маягтын дагуу үнэлж эрэмбэлээгүй байна.

3.13 Мөн төсвийн төсөлд тусгагдсан 15,309.8 төсөвт өртөг бүхий 15 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний байршил тодорхойгүй байна. (хавсралт №4)

3.14 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1¹⁵, 67 дугаар зүйлийн 67.3¹⁶ -т заасны дагуу төсвийн төслийг боловсруулахдаа олон нийтэд хүртээмжтэй байдлаар танилцуулж мэдээлсэн нь нотлогдохгүй байна.

3.15 Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 329,696.2 сая төгрөгийг 91 барилга, байгууламжид, 27,177.7 сая төгрөгийг 20 их засварт, 38,795.3 сая төгрөгийг 84 тоног төхөөрөмжид, 9,210.6 сая төгрөгийг 115 ТЭЗҮ-д, 6,520.0 сая төгрөгийг 3 бусад ангиллаар зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. ТАХ-ын ерөнхий мэдээлэл

(сая төгрөг)

Ангилал	Шилжих ТАХ			Шинэ ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	25	367,635.3	131,904.0	66	733,750.8	197,792.2	91	1,101,386.1	329,696.2
Их засвар	5	5,271.2	3,556.6	15	23,621.1	23,621.1	20	28,892.3	27,177.7
Тоног төхөөрөмж	6	7,583.6	7,048.7	78	31,746.6	31,746.6	84	39,330.2	38,795.3
ТЭЗҮ	42	5,277.1	2,348.6	73	6,862.0	6,862.0	115	12,139.1	9,210.6
Бусад	-	-	-	3	6,520.0	6,520.0	3	6,520.0	6,520.0
Нийт	78	385,767.2	144,857.9	235	802,500.5	266,541.9	313	1,188,267.7	411,399.8

Эх сурвалж: Аудитын судалгаа

3.16 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹⁷ -т “Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн

¹⁴ 35.1.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;

¹⁵ 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх

¹⁶ 67.3. Энэ хуулийн 67.1-д заасан төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга болон хот, тосгоны Захирагч олон нийтэд танилцуулж, тухайн засаг захиргааны нэгжид амьдарч байгаа иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд танилцуулна.

¹⁷ 4.1.24."хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэж заасан ч 2026 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 6,520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ нь өмчид бүртгэгдэхгүй ажил байна. Үүнд:

- “Уул уурхайн нөхөн сэргээлтийн чанар, хяналтыг сайжруулах, хариуцлага ногдуулах арга хэмжээг хэрэгжүүлэх” 20.0 сая төгрөг,
- “Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх” 500.0 сая төгрөг,
- “Шинэ хороолол” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, хөгжүүлэх, чөлөөлөх, нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөх” 6,000.0 сая төгрөг

3.17 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хувийн өмчид шилжих 1,025.0 сая төгрөгийн өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэхгүй байна. Үүнд:

- “Өрхийн газар тариалан эрхлэгчдэд бага оврын техник хэрэгслийг олгох” 525.0 сая төгрөг,
- “Орон сууцны нийтийн эзэмшлийг засварлах, гадна тохижилт, дээврийн засвар хийх” 500.0 сая төгрөг

3.18 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹⁸ -д хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, магадлалаар баталгаажсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон ТАХ-г тусгана гэж заасан байдаг.

3.19 Гэвч барилга байгууламжийн ангилалд хамаарах 1,101,386.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 91 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс 17,718.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ зураг, төсөвгүй байна.

Хүснэгт 7. Зураг, төсөвгүй барилга, байгууламж (сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	"Гурвансайхан" нисэх буудалд Олон Улсын захиалгат нислэг хүлээн авах зорилгоор өргөтгөл, шинэчлэл хийх	2026	2026	7,500.0	7,500.0
2	Даланзадгад сумын 3-р багт соёл, спорт, танхимын спортын төвийг байгуулах	2026	2026	5,000.0	5,000.0
3	Баяндалай сумын мал нядалгааны цэгийн барилга барих, тоног төхөөрөмжөөр хангах	2026	2026	692.3	692.3
4	Ноён, Сэврэй, Гурвантэс сумдын цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор 35кВ-ын шугам сүлжээ, дэд станц барих	2026	2026	2,526.5	2,526.5
5	Нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах, нутагшуулах төвийн ажлыг эхлүүлэх	2026	2026	800.0	800.0
6	Аймгийн Нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгын интерьер засал хийх	2026	2026	1,200.0	1,200.0
Нийт				17,718.8	17,718.8

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2026 оны төсвийн төсөл

3.20 Түүнчлэн тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг судалж тооцоогүй, төлөвлөлт, хянах тогтолцоо хангалтгүй байгаагаас дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Цогтцэций сумын цэцэрлэгүүдэд агаар сэлгэлтийн тоног төхөөрөмж суурилуулах 160.0 сая төгрөг
- “Багш нарыг зөөврийн компьютероор хангах” 600.0 сая төгрөг

¹⁸ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

3.21 “Цогтцэций сумын цэцэрлэгүүдэд агаар сэлгэлтийн тоног төхөөрөмж суурилуулах” 160.0 сая төгрөгийн ажлыг өмнөх онд Даланзадгад сумын бүх сургууль цэцэрлэгт суурилуулсан боловч зориулалтаар нь ашигладаггүй, шороо тоос ордог, улирал бүр урсгал зардал гардаг зэрэг нь байгууллагын төсөв, орон нутгийн онцлогт тохирохгүй байгааг байгууллагын удирдлага, багш нараас авсан судалгаагаар нотлогдсон,

3.22 Мөн 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Сургууль, цэцэрлэгийн багш нарыг компьютероор хангах” ажилд 2,770.8 сая төгрөг, 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 111.8 сая төгрөгийн өнгөт принтер, 154.8 сая төгрөгийн зөөврийн компьютер тус тус нийлүүлэгдсэн байхад дахин төсөвлөсөн байна.

3.23 Орон нутгийн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтаар дараах байгууллагуудад автомашин авахаар төлөвлөсөн байна.

*Хүснэгт 8. Шинээр авахаар төлөвлөсөн авто машины судалгаа
(сая төгрөг)*

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Сэргээн засах эмнэлгийг түргэн тусламжийн автомашинаар хангах	2026	2026	200.0	200.0
2	Татварын орлогыг бүрдүүлэх хүрээнд татварын газрыг шаардлагатай тээврийн хэрэгслээр хангах	2026	2026	250.0	250.0
3	Мал угаалга, ариутгал халдваргүйтгэлийн тусгай зориулалтын автомашинаар хангах, Мандал-Овоо сум	2026	2026	80.0	80.0
4	Сумын эрчим хүч, ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах машин механизмаар хангах /Мандал-Овоо, Хүрмэн, Баян-Овоо, Номгон, Баяндалай, Цогт-Овоо/	2026	2026	1,520.0	1,520.0
5	Сумдын шуудангийн хүртээмжийг нэмэгдүүлэх тээврийн хэрэгслээр хангах	2026	2026	340.0	340.0
6	Гурвантэс сумын Тос, Тосон бумба хамгаалалтын захиргааг автомашинаар хангах	2026	2026	200.0	200.0
7	"Дижитал өгөгдөл дата төв" ОНӨААТҮГ-н хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалт, багаж хэрэгсэл, автомашинаар хангах	2026	2026	580.0	580.0
8	Орон нутгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт “ХУРДАН” цэг байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх ажлын хүрээнд автомашинаар хангах	2026	2026	150.0	150.0
9	Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор төрийн байгууллагын автомашины бэлэн байдлыг хангаж, шинэчлэх	2026	2026	1,200.0	1,200.0
10	Цагдаагийн газрыг туулах чадвар сайтай автомашинаар хангах	2026	2026	200.0	200.0
11	Хилийн цэргийн 0166 дугаар ангийг туулах чадвар сайтай автомашинаар хангах	2026	2026	200.0	200.0
Нийт				4,920.0	4,920.0

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2026 оны төсвийн төсөл

3.24 Хэдийгээр байгууллагуудад автомашин авах хэрэгцээ шаардлага бий боловч байгууллагын үйл ажиллагааны чиглэл, онцлогт тааруулан моторын багтаамж, суудлын тоо зэргийг үндэслэлтэй тооцсоноор төсөвлөсөн дүнгээс буурах боломжтой байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

3.25 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэдээс санал аваагүй бөгөөд өмнөх оны авсан саналд үндэслэн 56,055.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 35,103.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

3.26 Урьд оноос шилжсэн “Даланзадгад сумын ундны усны 2-р эх үүсвэрийн ус түгээх цагариг шугам сүлжээнд ус түгээх байр, харуулын байр болон үлдэгдэл ажлуудыг гүйцэтгэж ашиглалтад оруулах” ТАХ нь 2023 оноос эхлэн хэрэгжсэн бөгөөд 2026 онд 4 дэх жилдээ хэрэгжиж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5¹⁹ дахь заалттай нийцэхгүй байна.

3.27 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх шаардлагатай байна.

3.28 Мөн Даланзадгадын дулаан дамжуулах төв №5-н хүчин чадлыг нэмэгдүүлэх, засвар шинэчлэл хийх 2,584.8 сая төгрөг, Аймгийн хэмжээнд цэвэр, бохирын шугамд холбогдох хөнгөлөлт үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх 1,000.0 сая төгрөгийн 2 ТАХ-г Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангуулан боловсруулах шаардлагатай байна.

Замын сангийн талаар:

3.29 Замын сангийн нийт хөрөнгийн 46.5 хувь буюу 13,943.8 сая төгрөгийн төсөвтэй 7 төсөл арга хэмжээ нь авто зогсоол байгуулах, 1.2 хувь буюу 372.9 сая төгрөгийн төсөвтэй 1 төсөл арга хэмжээ тоног төхөөрөмжөөр хангахаар төсөвлөсөн байгаа нь Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3.5.1²⁰, 3.5.2²¹ дахь заалтуудтай нийцэхгүй байна. Үүнд:

Хүснэгт 9. Журамд нийцээгүй төсөл арга хэмжээ (сая.төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Цогт-Овоо сумын төвийн авто зогсоолын байгуулах	2026	2026	4,155.8	4,155.8
2	Даланзадгад сумын Хүүхдийн ордон орчмын авто зогсоол байгуулах	2026	2026	475.0	475.0
3	Даланзадгад сум, 6-р сургуулийн авто зогсоол байгуулах	2026	2026	1,276.00	1,276.0
4	Даланзадгад сумын Угтах, үдэх хаалганы дэргэдэх нийтийн бие засах байрны авто зогсоол байгуулах	2026	2026	997.0	997.0
5	Морь барианы газрын авто зогсоол байгуулах	2026	2026	4,700.0	4,700.0
6	Даланзадгад-Баяндалай, Даланзадгад - Мандалговь чиглэлийн автозамын постын ачаа хэмжигч болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2026	2026	372.9	372.9
7	Даланзадгад сумын 3-р баг, Төв зам, уулзвар, авто зогсоолын өргөтгөл хийх	2026	2026	1,592.0	1,592.0
8	Даланзадгад сумын 2-р цэцэрлэгийн зогсоол байгуулах	2026	2026	748.0	748.0
Дүн				14,316.7	14.316.7

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2026 оны төсвийн төсөл

3.30 Автозам, замын байгууламжид хийх төсөл арга хэмжээг орон нутгийн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад төлөвлөх нь зүйтэй.

¹⁹ 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”

²⁰ 3.5.1-д “төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т тус тус заасан үйл ажиллагаанд”

²¹ 3.5.2-д “төсвийн 10 хүртэлх хувийг Авто замын тухай хуулийн 24.5-д заасан үйл ажиллагаанд”

Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгийн талаар:

3.31 Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэхээр 9,427.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 31 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

3.32 Өмнөх онд хэрэгжээгүй 70.0 сая төгрөгийн төсөвтэй Агаарын чанарын зөөврийн автомат багажаар хангах ТАН-г тооцоо судалгаагүйгээр 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 80.0 сая төгрөг болгосон бол өмнөх онд хэрэгжээгүй 1,000.0 сая төгрөгийн төсөвтэй Хог боловсруулах үйлдвэрт нэгдүгээр шугамын тоног төхөөрөмж нийлүүлэх ТАН-г 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,500.0 сая төгрөг болгон төсөвлөсөн байна.

3.33 Мөн Ханбогд сум Гашуун сухайт хилийн боомт болон цагаан хад суурьшлын бүсийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох гидрогеологийн эрэл хайгуулын ажил, нөөц батлуулах, улсын мэдээллийн санд бүртгүүлэх ажил 2025 оноос дамжин хэрэгжиж байгаа бөгөөд төсөвт өртгийг 92.6 сая төгрөгөөр үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн тооцсон байна.

3.34 2026 онд хийгдэх 31 арга хэмжээнээс 1,390.0 сая төгрөгийн 4 арга хэмжээ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.7²² дахь заалттай нийцэхгүй байна. Иймд арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг оновчтой төлөвлөх шаардлагатай.

Хүснэгт 10. Журамд нийцээгүй төсөл арга хэмжээ (сая.төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Даланзадгад сумаас Гурвантэс сум хүртэлх автозамын дагуу үйлчилгээтэй ариун цэврийн байгууламж байгуулах	2026	2026	500.0	500.0
2	Ноён, Сэврэй сумын Хонгорын хол, Булган сумын Баян загийг хог хаягдал тээвэрлэх Бункер үүрэгч автомашинаар хангах	2026	2026	510.0	510.0
3	Сумын төв, суурин газруудын айл өрхийн нүхэн жорлонгийн тоог бууруулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах	2026	2026	300.0	300.0
4	Байгаль орчноо хамгаалах үзлийг төлөвшүүлэх, нөлөөллийн ажлууд, “Эх орон - миний говь” танин мэдэхүйн аяллыг зохион байгуулах	2026	2026	80.0	80.0
ДҮН				1,390.0	1,390.0

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2026 оны төсвийн төсөл

3.35 Төсвийн төсөлд тусгасан 2,558.7 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээний урьдчилсан тооцоолол байхгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.223} дахь заалтыг зөрчиж байна.

Хүснэгт 11. Урьдчилсан тооцоололгүй төсөл арга хэмжээ (сая.төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	Экспортын тээврийн хатуу хучилттай авто зам, төмөр зам зэрэг шугаман дэд бүтцэд зэрлэг амьтдын дамжин өнгөрөх гарц, гармын ТЭЗҮ-г боловсруулан батлуулах	2026	2026	200.0	200.0
2	Хар сүүлт, Хулан адууны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2026	2026	300.0	300.0

²² 3.7-д “Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”

²³ 29.2-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”

3	Цоохор ирвэстэй нутагт мал болон ирвэс, зэрлэг амьтдыг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх	2026	2026	100.0	100.0
4	Амьтны тоо толгойг нэмэгдүүлэх, сэргээн нутагшуулах /Аргал, янгир, хойлог, хулан, хар сүүлт/	2026	2026	250.0	250.0
5	Зэрлэг амьтанд зориулж инженерийн хийцтэй худаг гаргах, орхигдсон худгийг сэргээн засах, уст цэг байгуулах судалгаа хийх	2026	2026	250.0	250.0
6	Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд иргэн, хуулийн этгээдийг үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах	2026	2026	80.0	80.0
7	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	2026	2026	150.0	150.0
8	Төв суурин газар болон малчдыг стандартад нийцсэн, цэвэр ундны усаар хангах ажлыг үе шаттай зохион байгуулж халдваргүйжүүлэх, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажлыг үе шаттай зохион байгуулах	2026	2026	200.0	200.0
9	Ундны усны аюулгүй байдлын 2026 оны төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлэх, төв суурины ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулах	2026	2026	400.0	400.0
10	Даланзадгад сумын орон сууцны хэрэглэгчдийн ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор зарим орон сууцны цэвэр усны хоолойд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах	2026	2026	264.80	264.80
11	Аймгийн ус цэг, усны хэмжилт, судалгаа, хяналт, шинжилгээний мэдээллийг нэгтгэх дата мэдээллийн сан үүсгэх	2026	2026	363.9	363.9
ДҮН				2,558.7	2,558.7

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2026 оны төсвийн төсөл

Хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаар:

3.36 Орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтыг 197 хөтөлбөр, арга хэмжээнд 144,997.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь өмнөх оноос 67 хөтөлбөр арга хэмжээгээр буюу 54,337.9 сая төгрөгийг нэмэгдүүлэн төлөвлөсөн байна

3.37 Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын (төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан үйл ажиллагаа явуулдаг болон явуулах) үйл ажиллагаанд санхүүжилт олгохоор тусгасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- “Энэрэл хүний хөгжлийн төв” ОНӨААТҮГ- 5,890.0 сая төгрөг
- "Итгэл дүүрэн амьдрал" ОНӨААТҮГ- 500.0 сая төгрөг,
- “Говь дент” ОНӨААТҮГ- 500.0 сая төгрөг,
- "Даланзадгад Зорчигч тээвэр" ОНӨААТҮГ-1,549.9 сая төгрөг,
- “Монгол тэмээ судлалын төв” ОНӨААТҮГ-350.0 сая төгрөг,

3.38 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгогдож байхад тус ажлыг давхардуулан “Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөр” баталж 2,500.0 сая төгрөгийн төсөлд зээл олгохоор төлөвлөсөн байна.

3.39 Хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тооцоололгүй 44 арга хэмжээнд 10,251.3 сая төгрөг зарцуулахаар тусгасан байна. (Хавсралт №5)

3.40 Мөн хөтөлбөр, арга хэмжээний зардлаас хөрөнгө оруулалтын шинжтэй 1,344.0 сая төгрөгийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. (Хавсралт №6)

ДӨРӨВ. ТӨСВИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг 25 хөтөлбөр, 26 зорилтот түвшнээр нэгтгэн боловсруулсан байна.

4.2 Боловсруулахдаа хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээтэй уялдуулан шинэчлээгүй, зарим хөтөлбөрийн зорилтот түвшин өмнөх онтой ижил, эсвэл бууруулсан нь зорилтот түвшнийг хангахад чиглээгүй болохыг харуулж байна. Тухайлбал:

Хүснэгт 12. Зорилтот түвшин ижил болон бууруулж төлөвлөсөн зарим хөтөлбөр

№	Хөтөлбөрийн нэр	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	
					2025 он	2026 он
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	Гэмт хэргийг бууруулна	2024	790	720	790
2	Ойжуулалт	Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт /хувь/	2024	93.6	95	94
3	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	Дундаж наслалт	2024	73.4	74	74
4	Ерөнхий боловсрол	Сургалтын чанар /хувь/	2024	79.5	88.5	81
5	Хот байгуулалт, тохижилт	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/	2023	210	224	224
6	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн...				
7	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	Зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт /хувь/	2024	60	40	20

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2026 оны төсвийн төсөл

4.3 Зарим хөтөлбөрийн төлөвлөсөн хүрэх үр дүн, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тооцож дүгнэхгүй байгаа нь нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэх, оновчтой сонгох боломжийг хязгаарлаж, төсвийн хөрөнгийг ач холбогдол багатай арга хэмжээнд зарцуулах эрсдэлийг дагуулж байна.

4.4 Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг харгалзаж үзээгүй, үр ашиггүй зардлыг нэмэгдүүлсэн, өртөг зардлын бодит тооцоолол, хэрэгцээ шаардлагыг үндэслээгүй, үр өгөөжийг тооцоогүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

4.7 Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.1²⁴, 17.1.2²⁵ дахь заалтуудыг зөрчин төрийн болон бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардуулан орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа нь үр ашиггүй зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

4.8 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр холбогдох хууль, журмаар хориглосон, тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй, өмнөх онд хийсэн хөрөнгө оруулалттай давхардсан, үр өгөөж нь тодорхойгүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. (Хавсралт №7)

²⁴ /чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх;/

²⁵ /төр, олон нийтэд үзүүлж байгаа үйлчилгээний орлогоор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулах, тухайн чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх;/

4.9 Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний 115 ажил төлөвлөсний 42 нь буюу 36.5 хувь нь он дамжин хэрэгжиж байгаа нь зураг төсвийн дагуу хийх хөрөнгө оруулалтын ажлууд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

4.10 Ижил төстэй зураг төсвийн ажлын төсөвт өртгийг түүвэрлэн үзэхэд харилцан адилгүй, өртөг тооцох жишиг тариф, судалгаанд үндэслэн бодитой тооцсон эсэх нь тодорхой бус 1,590.4 төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээ төлөвлөсөн байна. (Хавсралт №8)

4.11 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д *“техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй...”* гэж заасан ажлыг төсвийн төсөлд тусгахгүй байх гэж заасан байхад зураг төсвийн ажил нь дуусаагүй хавсралт №8-д дурдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа нь магадлалын дүгнэлтээр баталгаажихдаа төсөвт өртөг өөрчлөгдөх, худалдан авах ажиллагаа хуулийн хугацаанд²⁶ бүрэн дуусахгүй байх эрсдэл үүсэж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж болзошгүй байна.

4.12 Төсвийн ерөнхийлөн захирагч салбар бүрийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлагыг эрэмбэлэн, нэгдсэн судалгаа, мэдээллийг иж бүрэн, бодитой, үндэслэлтэй байдлаар нэгтгэн гаргаж, жил бүр шинэчлэн, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, шийдвэр гаргахдаа үндэслэл болгох нь зүйтэй байна.

²⁶ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1-д *“батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах,*

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Өмнөговь аймгийн 2026 хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд батлаагүй тул аймгийн 2026 оны төсвийн төслийг хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг төсөвтэй уялдуулан төлөвлөөгүй байна.
3. Аймгийн үнэт цаас гаргаж, нийт өрийн үйлчилгээний төлбөрийг 2026-2030 оны хооронд төлж барагдуулахаар урьдчилан төлөвлөсөн нь өрийн удирдлага болон эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх шаардлагыг үүсгэж байна.
4. Татварын орлогыг нэр төрлөөр бодитой тооцож төлөвлөөгүй нь орлого тасрах эрсдэл дагуулж байна.
5. Татварын бус орлогыг төлөвлөхдөө орлого нэмэгдүүлэх боломжийг судалж тусгаагүй байна.
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэх тоног төхөөрөмжийн үнэ, өртгийн урьдчилсан судалгаа хийх, судалгаанд үндэслэн төсөвт өртгийг, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг харгалзан байршил, тоо хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.
7. Хөрөнгө оруулалт болон хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төрөл, төсөвт өртгийн ялгаа, эрэмбэ, ач холбогдол тодорхойгүй байгаа нь хөрөнгө санхүүгийн нөөцийн оновчгүй хуваарилалт, үр дүнгүй зарцуулалтад эрсдэлийг дагуулж байна.
8. Хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрэх үр дүн, төсвийн тооцоог бодитой тодорхойлсноор төсвийн үр ашиг дээшлэх боломжтой байна.
9. Үр ашиггүй зардлыг нэмэгдүүлсэн, төсөвт өртгийг бодитой тооцоогүй, хэрэгцээ шаардлагад үндэслээгүй төлөвлөлт хийсэн нь санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг хязгаарлаж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэлэлцэн батлах цаглаварт хугацааг мөрдөж ажиллах;
2. Аймгийн үнэт цаас гаргаж байгаатай холбогдуулан Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Засгийн газрын 2024 оны 168 дугаар тогтоолоор баталсан “Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ын 5.4.1-т заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах;
3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 -д заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийг байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, Улсын их хурлын болон Засгийн газрын тогтоолд нийцүүлэн, тооцоо судалгаатай, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг бодитой үнэлж, төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардуулахгүй байхад анхаарах;

Аймгийн Засаг даргад:

1. Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтыг хэрэгжүүлж төсвийн төслийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангаж ирүүлэх;
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийг хэрэгжүүлж Төсвийн төслийн төлөвлөлтөд чанарын үнэлгээ хийх;
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулах;
4. Төсвийн төслийг төлөвлөхөд олон нийтийн хэлэлцүүлгийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, салбар бүрийн иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодыг хамруулж, тэдгээрийн үр дүнг тусгах;
5. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах, татварын өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх;

АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЭЛД НОГДУУЛСАН АЛБАН ТАТВАРЫН ТООЦООЛОЛ

/төгрөгөөр/

№	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Өмнөговь аймгийн татварын газарт бүртгэлтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тоо	Аймгийн ИТХ-ын 2025 оны 4/28 дугаар тогтоолоор баталсан төлбөр ногдуулах хэмжээ	Аймгийн татварын газрын тооцооллоор	Аудитын тооцооллоор
1	2 дугуйтай мотоцикл	826	3,225	2,663,850.0	2,663,850.0
2	Суудлын автомашин:	20,629	85	1,059,227,005.0	1,059,227,005.0
	A/ 2001 см3 хүртэл	12,296	24	441,475,584.0	441,475,584.0
	Б/ 2001 - 3001 см3 хүртэл	4,843	27		261,652,761.0
	В/ 3001 см3 болон түүнээс дээш	3,490	34		356,098,660.0
3	Микроавтобус /15 хүртэл суудалтай/	675	47,250	31,893,750.0	31,893,750.0
4	Автобус	460	69,000	31,740,000.0	31,740,000.0
5	Ачааны автомашин	6,630	6,250,500	764,458,500.0	764,458,500.0
	1. 1 хүртэл тн-ын даацтай	3,385	33,750	114,243,750.0	114,243,750.0
	2. 1-2 тн-ын даацтай	988	47,250	46,683,000.0	46,683,000.0
	3. 2-3 тн-ын даацтай	345	60,750	20,958,750.0	20,958,750.0
	4. 3-5 тн-ын даацтай	372	74,250	27,621,000.0	27,621,000.0
	5. 5-8 тн-ын даацтай	93	108,000	10,044,000.0	10,044,000.0
	6. 8-10 тн-ын даацтай	42	121,500	5,103,000.0	5,103,000.0
	7. 10-20 тн-ын даацтай	641	150,000	96,150,000.0	96,150,000.0
	8. 20-30 тн-ын даацтай	131	225,000	29,475,000.0	29,475,000.0
	9. 30-40 тн-ын даацтай	138	300,000	41,400,000.0	41,400,000.0
	10. 40-50 тн-ын даацтай	54	450,000	24,300,000.0	24,300,000.0
	11. 50-60 тн-ын даацтай	43	540,000	23,220,000.0	23,220,000.0
	12. 60-70 тн-ын даацтай	78	630,000	49,140,000.0	49,140,000.0
	13. 70-80 тн-ын даацтай	122	720,000	87,840,000.0	87,840,000.0
	14. 80-90 тн-ын даацтай	47	855,000	40,185,000.0	40,185,000.0
	15. 90-100 тн-ын даацтай	31	945,000	29,295,000.0	29,295,000.0
	16. 100 тн-оос дээш даацтай	120	990,000	118,800,000.0	118,800,000.0
6	Тусгай зориулалтын автомашин	15,533	33,750	334,741,621.0	334,741,621.0
7	Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл	1,067	25,200	26,888,400.0	26,888,400.0
8	Бага оврын трактор	8	9,450	75,600.0	75,600.0
9	Чиргүүл /даацын 1 тонн тутамд/	24,876	12,375	15,392,025,000.0	15,392,025,000.0
Нийт дүн		70,704	-	17,025,962,305.0	17,643,713,726.0
Зөрүү орлого нэмэгдүүлэх саналд тусгах дүн					617,751,421.0

Хавсралт-2

АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЭЛД НОГДУУЛСАН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ
АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ

				/төгрөгөөр/
№	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Өмнөговь аймгийн татварын газар бүртгэлтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тоо	Аймгийн ИТХ-н 2025 оны 4/30 дугаар тогтоолын төлбөрийн хэмжээ	Автозам ашигласны төлбөрийн нийт хэмжээ
1	2 дугуйтай мотоцикл	826	3,000.0	2,478,000.0
2	3 дугуйтай мотоцикл	-	3,000.0	-
	Суудлын автомашин:	20,629	34,500.0	202,686,000.0
3	А/ 2001 см3 хүртэл	12,296	7,500.0	92,220,000.0
	Б/ 2001 - 3001 см3 хүртэл	4,843	12,000.0	58,116,000.0
	В/ 3001 см3 болон түүнээс дээш	3,490	15,000.0	52,350,000.0
4	Микроавтобус /15 хүртэл суудалтай/	675	30,000.0	20,250,000.0
5	Автобус	460	37,500.0	17,250,000.0
6	Ачааны автомашин	6,630	637,000.0	169,269,000.0
	1. 1 хүртэл тн-ын даацтай	3,385	19,500.0	66,007,500.0
	2. 1-2 тн-ын даацтай	988	19,500.0	19,266,000.0
	3. 2-3 тн-ын даацтай	345	22,500.0	7,762,500.0
	4. 3-5 тн-ын даацтай	372	22,500.0	8,370,000.0
	5. 5-8 тн-ын даацтай	93	27,000.0	2,511,000.0
	6. 8-10 тн-ын даацтай	42	36,000.0	1,512,000.0
	7. 10-20 тн-ын даацтай	641	40,000.0	25,640,000.0
	8. 20-30 тн-ын даацтай	131	50,000.0	6,550,000.0
	9. 30-40 тн-ын даацтай	138	50,000.0	6,900,000.0
	10. 40-50 тн-ын даацтай	54	50,000.0	2,700,000.0
	11. 50-60 тн-ын даацтай	43	50,000.0	2,150,000.0
	12. 60-70 тн-ын даацтай	78	50,000.0	3,900,000.0
	13. 70-80 тн-ын даацтай	122	50,000.0	6,100,000.0
	14. 80-90 тн-ын даацтай	47	50,000.0	2,350,000.0
	15. 90-100 тн-ын даацтай	31	50,000.0	1,550,000.0
	16. 100 тн-оос дээш даацтай	120	50,000.0	6,000,000.0
7	Тусгай зориулалтын автомашин	15,533	50,000.0	776,650,000.0
8	Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл	1,067	10,000.0	10,670,000.0
9	Бага оврын трактор	8	10,000.0	80,000.0
10	Чиргүүл /даацын 1 тонн тутамд/	24,876	50,000.0	1,243,800,000.0
11	Цахилгаан тэжээлт автомашин	-	10,000.0	-
Нийт дүн		70,704		2,443,133,000.0
		Аймгийн 2026 оны төсөвт тусгасан санал		300,000,000.00
		Зөрүү дүн		2,143,133,000.00
		Тайлант оны өрийг 80 хувь барагдуулахаар тооцож орлого нэмэгдүүлэх саналд тусгах дүн		1,714,506,400.00

ОЛБОРЛОСОН ТҮҮХИЙ НҮҮРСЭД НОГДУУЛСАН АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу /2026-06-01-ээс мөрдөх/ Аймгийн ИТХ-ын 2025 оны 4/29 дугаар тогтоолоор олборлосон нүүрсний килограмм тутамд 2 төгрөгийн төлбөр ногдуулахаар тогтоосон байна.

№	Аж ахуй нэгжийн нэр	Экспортод гаргасан нүүрсний хэмжээ /тн/			Аудитаар тооцоолсон агаарын бохирдлын төлбөрийн дүн /төгрөгөөр/
		2024 он	2025 оны 10 сар	2026 оны сүүлийн хагас жилийн төсөөлөл	
1	Монголын алт МАК ХХК	9,964,252.0	11,467,928.0	5,733,964.0	11,467,928,000.0
2	Саусгоби сэндс ХХК	7,519,001.0	9,107,902.3	4,553,951.2	9,107,902,300.0
3	Өсөхзоос ХХК	2,734,724.0		-	-
4	Хүрэн толгой коал майнинг ХХК	1,831,369.0	2,098,214.5	1,049,107.3	2,098,214,540.0
5	Цагаан өвөлжөө ХХК	1,120,129.0	688,640.6	344,320.3	688,640,550.0
6	Жавхлант орд ГХО-тай ХХК	700,242.0	282,171.8	141,085.9	282,171,780.0
7	Хур эрдэнэ баялаг ГХО-тай ХХК	464,850.0	36,660.0	18,330.0	36,660,000.0
8	Өсөх зоос алтан говь ГХО-тай ХХК	123,703.0	2,110,304.4	1,055,152.2	2,110,304,400.0
9	Эрдэнэс Таван толгой ХК	27,228,208.1	20,695,442.9	10,347,721.5	20,695,442,900.0
10	Энержиресурс ХХК	7,671,144.3	5,256,960.9	2,628,480.5	5,256,960,900.0
11	Тавантолгой ХК	3,221,282.4	1,322,156.5	661,078.3	1,322,156,500.0
12	Хангад-Эксплорэйшн ХХК /ГХО/	981,614.6	1,278,224.3	639,112.2	1,278,224,300.0
13	Мөнхноён суварга	126,014.9		-	-
Нийт		63,758,082.3	54,344,606.2	27,172,303.1	54,344,606,170.0
		Төсвийн орлого нэмэгдүүлэх саналд тусгах дүн			27,172,303,085.0

ЖИЧ: Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 "Төлбөр төлөгч нь тухайн улиралд олборлосон түүхий нүүрсэнд ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны дотор харьяалах татварын албанд төлж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ"-д заасан учраас 3 дугаар улирлын төлбөрийг 2026 оны төсөвт төвлөрөх боломжтой гэж үзсэн.

Байршил тодорхойгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

/сая төгрөгөөр/

№	Төсвийн төслийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	6	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2026	2026	700.0	700.0
2	39	Шинээр орон нутагт хөгжиж буй спортыг хөгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах	2026	2026	120.0	120.0
3	63	Даланзадгад сумын авто замыг нэмэгдүүлэх уулзварын өргөтгөлийн зураг төсөл боловсруулах	2026	2026	400.0	400.0
4	64	Даланзадгад сумын амины орон сууцны 35 га -ын гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулах	2026	2026	85.0	85.0
5	87	Хөв цөөрмийн түшиглэн ойн зурвас байгуулах ТЭЗҮ боловсруулах /5 хөв цөөрөм/	2026	2026	70.0	70.0
6	94	Булаг шандыг хашиж хамгаалах хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөл боловсруулах /5 суманд/	2026	2026	75.0	75.0
7	149	Даланзадгад сумын авто зам, уулзварын өргөтгөлийн зураг төсөв боловсруулах	2025	2026	291.0	116.4
8	158	Төрийн захиргааны барилгын зураг төсөв боловсруулах	2025	2026	111.5	66.9
9	196	Даланзадгад сумын амралт зугаалгын нийтийн эзэмшлийн талбай байгуулах	2026	2027	21,670.0	10,800.0
10	209	Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2026	2026	500.0	500.0
11	273	Нутгийн удирдлагын ордны хурлын танхимыг засварлах, тоног төхөөрөмжийг шинэчлэх	2026	2026	476.5	476.5
12	277	Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	2026	2026	200.0	200.0
13	278	Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор төрийн байгууллагын автомашины бэлэн байдлыг хангаж, шинэчлэх	2026	2026	1,200.0	1,200.0
14	292	Төрийн болон албаны нууцын биет хамгаалалтыг сайжруулах	2026	2026	50.0	50.0
15	294	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	2026	2026	450.0	450.0

Орц, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтгүй хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт

			Хэрэгжих хугацаа		Аудитаар			/сая төгрөг/
№	6-р Хавсралтын дэс дугаар	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	эхлэх	дуусах	Төлөвлөсөн дүн	Тооцоолол	Бууруулах боломжит дүн	Үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр тооцоолсон эсэх
Хөгжлийн бодлого, төлөвлөлт								70.0
1	101	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд чиглэсэн чуулга уулзалт, сургалт зохион байгуулах, албан хаагчдыг орлоцуулах	2026	2026	150.0	80.0	70.0	Оролцогчдын тээвэр шатахууны зардалд 25.0 сая төгрөг, хоолны зардалд 20.0 сая төгрөг, соёлын арга хэмжээний зардалд 25.0 сая төгрөгийн зардлууд төлөвлөсөн
Хот байгуулалт, газрын харилцаа								250.0
2	104	Газар өмчлөлийн системийг байгуулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын өмчлөлийн бүртгэлийн мэдээллийн сантай холбож дундын мэдээллийн сан үүсгэх, татвар ногдуулах боломжийг бүрдүүлж, хэрэглэнд нэвтрүүлэх	2025	2026	250.0	-	250.0	Нотлох баримт ирүүлээгүй
Санхүү, төсвийн зохицуулалтын салбар								795.0
3	107	Өмнөговь аймгийн татварын орлогын бааз суурийг тэлэх үе шаттай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, зөвлөх үйлчилгээ авах	2026	2026	500.0	150.0	350.0	Татварын хуулиудыг хэрэгжүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн татварын орчныг судлан үнэлгээ хийх ажлын даалгавар боловсруулах 350.0 сая, Татварын хуулиудыг хэрэгжүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн татварын орчныг судлан үд дүнг тооцох, зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгавар боловсруулах 200.0 сая гэж төлөвлөсөн нотлох баримт ирүүлээгүй
4	110	"Татвар төлөгчийн өдрүүд-2026" арга хэмжээг зохион байгуулах	2026	2026	200.0	80.0	120.0	Татвар төлөгч нарт талархлын арга хэмжээ, шилдэг татвар төлөгчдөө шалгаруулах 50.0 сая, татвар төлөгчийн дунд зохион байгуулах спортын арга хэмжээ 30.0 сая, татварын хуулийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах контент хийх 40.0 сая төгрөгийн зардлууд нь байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн
5	111	Аймгийн санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, олон улсын стандартын нэвтрэлтийг нэмэгдүүлэх	2026	2026	500.0	345.0	155.0	Сургалтын төлбөр, болон сургалт зохион байгуулахтай холбоотой бусад зардал гэсэн нь яаж зарцуулах эсэх нь үндэслэлгүй төлөвлөсөн
6	112	Иргэд олон нийт, хүүхэд залуучуудад санхүүгийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах	2026	2026	350.0	180.0	170.0	Сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах 70.0 сая төгрөгийг зардал гэж ерөнхий дүнгээр төлөвлөсөн, Видео хичээл, контент, зурагт хуудас бэлтгэх Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Цахим хуудсаар дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг түгээх зардалд 100.0 сая гэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зарчин төлөвлөсөн
Байгаль орчны салбар								570.0
8	162	"Нутгийн заг" Манлай, Ханбогд, Баян-Овоо, Номгон, Цогтцэций, Булган, Ноён, Гурвантэс, Сэврэй суманд ТЭЗҮ-г үндэслэн ойжуулалт хийх	2026	2026	900.0	380.0	520.0	Манлай, Ханбогд, Баян-Овоо, Номгон, Цогтцэций сумдын ТЭЗҮ гараагүй байхад заган ойжуулалт гэж үндэслэлгүй төлөвлөсөн
9	164	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, арга хэмжээг зохион байгуулах	2026	2026	150.0	100.0	50.0	Өмнөх оны гүйцэтгэлээр усны холбогдолтой тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээгээр спортын арга хэмжээ зохион байгуулж зардлыг санхүүжүүлсэн, форумыг зохион байгуулахдаа буудал, хоол, худдаасан хэвлэл гэх мэт үр ашгийг зардал гаргасан байгааг дахин төлөвлөсөн
БҮСИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								150.0
10	7	"Тэрбум мод тарих үндэсний өдөр"-г зохион байгуулах, мод тарьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлийг урамшуулах	2025	2026	950.0	800.0	150.0	Өмнөх оны төсвөөс хэт өндөр тооцож, үндэслэлгүй нэмэгдүүлэн төсөвлөсөн
Нийтийн биеийн тамир, спорт								207.0
11	64	Хувийн хөрөнгө оруулалтаар спорт, баялдаржуулах клуб эрүүл зөв хэв маягийг ард иргэдэд хэвшүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг бодлогоор дэмжих	2026	2026	500.0	293.0	207.0	Төсвийн төлөвлөлт нь нотлогдохгүй байна.
Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн салбар								830.0
12	121	Хариуцлагатай уул уурхайн найман зарчмыг байгаль орчныг хамгаалах тэтгэх түншлэлээр дамжуулан хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны гэрээний талаар мэдээлэл хүргэх зөвлөгөөнийг сумдад бүсчлэн зохион байгуулах	2026	2026	150.0	-	150.0	Төсвийн төлөвлөлт нь нотлогдохгүй байна. / Албан томилолтын зардал, байрны зардал, хоолны зардал давхардуулан төсөвлөсөн, уух зүйлс, тараах материалын зардлыг бодитой тооцоогүй, нэг бүрийн үнийг хэт өндөр тооцсон/
13	122	Уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтцийн төслийн нийгмийн нөлөөлөл, индекс, хамтын ажиллагааны механизмыг бий болгох зөвлөх үйлчилгээ	2026	2026	250.0	-	250.0	
14	124	Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор томоохон туслан гүйцэтгэгч компаниуд хамтын ажиллагааны гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа зохион байгуулах	2026	2026	150.0	-	150.0	
15	125	Гар аргаар алт болон бусад түүхий эд олборлогч иргэдэд сургалт зохион байгуулах	2026	2026	40.0	-	40.0	
16	126	Гар аргаар алт болон бусад түүхий эд олборлогчдод зориулсан сорьцын хяналтын лаборатори байгуулах ажлыг эхлүүлэх	2026	2026	160.0	-	160.0	
17	127	Уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтцийн төслүүдэд орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийг ханган нийлүүлэгчээр оролцох боломжийг нэмэгдүүлэх	2026	2026	80.0	-	80.0	
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбар								461.9
18	132	"Чинээлэг малчин өрх" хөтөлбөрийн хүрээнд зурамтайн цагаан ямааны судалгааны ажлыг үргэлжлүүлэх, Говь шанхын адууг өмгөөр баталгаажуулах	2026	2026	50.0	10.2	39.8	Ангилалт хийх зардлыг давхардуулан тооцсон, зарим хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхойгүй,тооцоо судалгаа байхгүй
19	135	"Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн чанарыг сайжруулах, малчдыг зорилго чиглэлийн дагуу төрөлжсөн сургалт арга хэмжээг зохион байгуулах, хамруулах	2026	2026	100.0	-	100.0	Малчдын зөвлөгөөн зохион байгуулах арга хэмжээнд төсвөөс хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөнтэй давхардуулан тооцож төлөвлөсөн
20	138	Говь гурван сайхан үүлдрийн ямааг өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулах, сүргийн бүтцийг хамгаалах	2026	2026	22.1	-	22.1	Төсвийн төлөвлөлт нь нотлогдохгүй
21	142	Газар тариалан эрхлэх бааз суурийг өргөжүүлэн "Агропарк" сургалтын төвд давхар нийлэг хальсан хүлэмж байгуулах	2026	2026	40.0	-	40.0	
22	143	Номгон сумын Эрдэнэбулаг, Баянбулаг усгалтын системүүдийн тариалангийн талбайн хөрс сайжруулах	2026	2026	40.0	-	40.0	
23	144	Тариалангийн талбайн агрохими, агрофизикийн шинжилгээ хийлгэх	2026	2026	20.0	-	20.0	
24	146	Хүнсний хувьсгал аяны төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх	2026	2026	200.0	-	200.0	2027 онд зохион байгуулагдах бүсийн арга хэмжээг оруулан тооцсон, Туршлага судлах арга хэмжээ нь "Хөгжлийн гүүр" хөтөлбөртэй давхцуулан тооцсон, хэрэгжүүлэх зарим арга хэмжээ тодорхойгүй, тооцоо судалгаагүй
Аялал жуулчлалын салбар								524.5
25	148	Өмнөговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт төлөвлөгөөг хэрэгжүүлэх, уламжлал болсон эвент арга хэмжээг орон нутгийн иргэд, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, аялал жуулчлалын олон улсын болон дотоодын үзэсгэлэн, уулзалт, зөвлөгөөн, сургалтад оролцох, сурталчлах	2026	2026	1,687.0	1,312.5	374.5	Захиргаа, зохион байгуулалтын зардалд 141.5 сая төгрөг, Соёлын арга хэмжээний зардалд 233.0 сая төгрөгөөр тооцож төсөвлөсөн нь Төрийн хэмэлтийн тухай хуулийн хэмнэх заалттай уялдаагүй байна.
26	153	Цайны замын түүхэн дурсгалыг сурталчлах зорилгоор Хөх хотоос Ханбогдын Хүрдэт агуй, Баянзаг, Хархорин хүрэх Монгол-Хятадын хамтарсан авто ралли зохион байгуулах, Бээжин-Хөх хот-Даланзадгад- Хархорин-Ховд-Улиастай-Казахстан чиглэлд олон улсын авто аяллын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2026	2026	250.0	160.0	90.0	Захиргаа, зохион байгуулалтын зардалд 90.0 сая төгрөг зарцуулахаар бөөн дүнгээр төлөвлөн төсөвт тусгасан нь Төрийн хэмэлтийн тухай хуулийн хэмнэх заалттай уялдаагүй төлөвлөсөн байна.

27	154	"Аялал жуулчлалыг – Бүх нийтэд" уриалгыг хэрэгжүүлэх, орон нутгийн иргэдийн аялал жуулчлалаас хүртэх ашиг орлогыг нэмэгдүүлэх, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, уулзалт арга хэмжээ, Цайны зам ОУАХ-нд орон нутгийн өв соёлыг сурталчлан оролцох	2026	2026	160.0	100.0	60.0	Захиргаа, зохион байгуулалтын зардалд 60.0 сая төгрөг зарцуулахаар бөөн дүнгээр төлөвлөн төсөвт тусгасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмхэн заалттай уялдаагүй төлөвлөсөн байна.
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, салбарын хяналт								90.0
28	166	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шалгалтыг гүйцэтгэх, албан хаагчдыг чадавжуулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах	2026	2026	100.0	10.0	90.0	Төсвийг үндэслэлгүй илүү тооцон төсөвлөсөн
Амар тайван аюулгүй нийгэм								2,035.9
29	174	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигын хор хохирлыг арилгах, хариу арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх	2026	2026	5,000.0	3,000.0	2,000.0	2025 онд 1,000.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Нэмж хэрхэн төлөвлөсөн материал ирүүлээгүй
30	175	"Тамшигт тэсвэртэй орон нутаг" нөлөөллийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах	2026	2026	200.0	186.1	13.9	Бичиг хэргийн зардлыг давхардуулан тооцож, шатахуун, албан томилолтын зардлыг олгохоор төлөвлөсөн
31	176	Гамшигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ур чадвар олгох зорилгоор "Өсвөрийн аврагч-2026" аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	2026	2026	45.0	23.0	22.0	Өмнөх оны уг арга хэмжээний хэрэгжилтээс давтан ашиглах боломжтой хэрэглэгдэхүүн, материалыг давхардуулан тооцож төсөвлөсөн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн "Хэмнэлт хэрэгжүүлэх зарчим"-тай нийцээгүй
Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого								20.0
32	192	Гадаад хамтын ажиллагаа бүхий улс орнуудтай найрсаг харилцааг хөгжүүлэх	2026	2026	250.0	230.0	20.0	АЗДТ-ын Олон нийттэй харилцах албаны чиг үүргийн ажлыг төсөвлөн тооцсон байна.
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал								1,390.0
33	83	Гэр бүлийн гишүүдийн хөгжил, харилцаа хандлагад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх	2026	2026	200.0		200.0	
34	81	Хүүхэд, эмэгтэйчүүдийг боловсрол эрсдэл, бэлгийн мөхлөг, хүчирхийлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	2026	2026	200.0		200.0	
35	94	Ахмад настныг эрүүл мэнд, танин мэдэхгүй, шинээр суралцахуйн үйл ажиллагааг дэмжих	2026	2026	300.0		300.0	
36	95	Ахмад настны хөгжил, хамгаалал, оролцоонд тулгуурласан үйл ажиллагааг дэмжих	2026	2026	250.0		250.0	
37	96	Ахмад настны эрүүл урт, удаан насжилтыг дэмжих чиглэлээр төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих	2026	2026	400.0		400.0	
38	91	Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон асран хамгаалагчдын боловсролыг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулах	2026	2026	40.0		40.0	
Шинжлэх ухаан, технологи, инноваци								200.0
39	98	Хувьцанг хогийг дахин боловсруулж барилгын материал хуванцар хоолой хийх бага оврын өрхийн үйлдвэрлэл төхөөрөмжийн судалгаа хэрэгжүүлэх	2026	2026	50.0	-	50.0	Төсвийн төлөвлөлт нь нотлогдохгүй байна. /тооцоо судалгаа ирүүлээгүй/
40	99	Саарал ус дахин цэвэршүүлж хэрэглэх технологийн хэрэглээ, судалгаа хийх	2026	2026	70.0	-	70.0	Төсвийн төлөвлөлт нь нотлогдохгүй байна. /тооцоо судалгаа ирүүлээгүй/
41	100	Эко цахилгаан хэрэглээг нэвтрүүлэхэд чиглэсэн сургалт судалгааг хөгжүүлэх нар салхинаас эрчим хүч гаргах талаар өрхийн хэрэглээний чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх	2026	2026	80.0	-	80.0	Төсвийн төлөвлөлт нь нотлогдохгүй байна. /тооцоо судалгаа ирүүлээгүй/
Үндэсний бахархал, өв соёл, урлаг								1,650.0
42	62	Номын "Шидэт хайрагч", "1000 ном" төслийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх	2026	2026	1,400.0	-	1,400.0	Төсвийн төлөвлөлт нь нотлогдохгүй байна. /тооцоо судалгаа ирүүлээгүй/
43	55	Соёл урлагийн байгууллагын ажилчдын мэргэжил ур чадварыг нэмэгдүүлэх, орон нутагтаа шинээр бүтээн турвисан Үндэсний болон сонгодог уран бүтээлийг дэмжиж ажиллах	2026	2026	400.0	150.0	250.0	Төсвийн төлөвлөлт нь нотлогдохгүй байна. /тооцоо судалгаа ирүүлээгүй/
Хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэчлэл								1,007.0
44	190	Гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийн цагдааг ажилуулах	2026	2026	1,007.0	-	1,007.0	Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.
НИИТ ДҮН								10,251.3

Хөтөлбөр, арга хэмжээний зардлаас хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

№	6-р Хавсралтын дэс дугаар	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төлөвлөсөн дүн	Аудитаар	
			эхлэх	дуусах		Хасах боломжтой дүн	Үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр тооцоолсон эсэх
Барилга, орон сууцжуулалд, нийтийн аж ахуйн салбар						150.0	
1	157	"Хашаандаа сайхан амьдарцгаая" хөтөлбөр хэрэгжүүлэх	2026	2026	400.0	150.0	Эрчим хүчний хэмнэлттэй халаагуур зарах цэг байгуулах
Аялал жуулчлалын салбар						650.0	
2	149	Баянзаг орчмын аялал жуулчлал, байгаль орчны нөөц даацын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	2026	2026	80.0	80.0	Хөрөнгө оруулалтын шинжтэй
3	150	Өмнөговь аймгийн “Аялал жуулчлалын мастер” төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	2026	2026	180.0	180.0	
4	151	Хонгорын гол, Баянзаг, Дэмчогийн хийд болон хил орчмын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах	2026	2026	250.0	250.0	
5	152	Баянзагийн археологийн өв, аялал жуулчлалыг хослуулах судалгааны ажил хийх	2026	2026	140.0	140.0	
Байгаль орчны салбар						544.0	
6	161	"Өмнөговь-Ногоон хэрэм"-г трансн дагуу үргэлжлүүлж хашаа, худаг, услалтын систем, нөөцийн сав суурилуулж, модны нүх ухах	2025	2026	1,125.0	544.0	Гүн өрмийн худаг гаргаж бүрэн тоногжуулах
Нийт дүн						1,344.0	

Төсвийн төсөлд тусгасан үр өгөөж нь тодорхойгүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Тайлбар
1	Сэргээн засах эмнэлгийг түргэн тусламжийн автомашинаар хангах	200.0	Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйл, сэргээн засах төвийн үзүүлэх, тусламж үйлчилгээтэй нийцэхгүй байна.
2	Хуучин гэрэлт хөшөө цогцолборыг сэргээн байгуулах ажлын зураг төсөл боловсруулах	50.0	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.1, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.3, 3.2.4 дэх заалттай нийцэхгүй байна.
3	Даланзадгад суманд эрүүл ахуй стандартын шаардлага хангасан мал нядалгааны газар байгуулах	1967.4	УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 2.2.6-д зааснаар орон нутгийн хөгжлийн төв Даланзадгад сум, түүнд таталцах сумд нь Цогт-Овоо, Номгон, Баяндалай байтал эдгээр сумдад барихаар төлөвлөсөн байна. Иймд бүсчлэлийн тогтолцоогоор, эдийн засгийн төрөлжилт бий болгож төлөвлөж, Цогт-Овоо суманд байгуулсан мал нядалгааны газрын үйл ажиллагааг эхлүүлэн үр ашиг, өгөөжийг тооцох нь зүйтэй.
4	Номгон сумын мал нядалгааны цэгийн барилга барих, тоног төхөөрөмжөөр хангах	692.3	
5	Баяндалай сумын мал нядалгааны цэгийн барилга барих, тоног төхөөрөмжөөр хангах	692.3	
6	Даланзадгад болон бусад сумдын гудамж, талбайн камерын засвар болон алслагдсан сум, багийн нутгийн үүрэн холбооны сүлжээний байгууламжийг засварлах, ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангах	1800.4	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.4 дэх заалттай нийцэхгүй байна.
7	Алслагдсан сум, багийн нутагт үүрэн холбооны сүлжээний тархалтыг нэмэгдүүлж, өрх бүрд өндөр хурдны интернет, утасны сүлжээ хүргэх боломжийг бүрдүүлэх, гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх /Ноён, Цогт-Овоо, Хүрмэн, Даланзадгад/	1000.0	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 6/19 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтын 9.3.12-т “Алслагдсан сум, багийн нутагт үүрэн холбооны сүлжээний тархалтыг нэмэгдүүлж, өрх бүрд өндөр хурдны интернет, утасны сүлжээ хүргэх боломжийг бүрдүүлэх, гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх /Манлай, Цогт-Овоо, Баяндалай, Сэврэй, Ханхонгор, Мандал-Овоо, Хүрмэн, Булган, Баян-Овоо” ажлыг төлөвлөн гүйцэтгэгч шалгарсан бөгөөд тус ажил хийгдсэн сумдыг төлөвлөлтөд дахин хамруулсан байна.

Төсөвт өртөг харилцан адилгүй төлөвлөсөн ТЭЗҮ боловсруулах төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Даланзадгад сумын 3-р багт хүүхэд залуучуудын төвийн барилгын зураг төсөл	120.0	Даланзадгад сумын 1-р багт хүүхэд залуучууд, ахмадуудад зориулсан спорт заал, фитнес төв, бүжгийн заал бүхий төв байгуулах зураг төсөл боловсруулах	80.0
2	Орон сууцны 20 айлын нэг маягийн зураг төсөл боловсруулах. /Манлай, Ханхонгор, Сэврэй, Мандал-Овоо, Номгон, Баяндалай, Хүрмэн, Булган, Цогт-Овоо/	250.0	10 айлын нэг маягийн зургийг суманд холболт хийх	20.0
3	Сэврэй, Хүрмэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	300.0	Гурвантэс, Баян-Овоо, Ханбогд, Цогтцэций сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	440.8
4	Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн их засварын зураг төсөл боловсруулах	40.0	Нутгийн удирдлагын ордны их засварын зураг төсөл боловсруулах	120.0
5	Цогт-Овоо, Манлай, Цогтцэций сумдад шинээр хөв цөөрөм байгуулах зураг төсөв боловсруулах	119.6	Ханбогд сумын Ундайн голыг түшиглэн хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөв	100.0

“Энэрэл хүний хөгжлийн төв” ОНӨААТҮГ -ын чиг үүргийн талаарх судалгаа

№	“Энэрэл хүний хөгжлийн төв” ОНӨААТҮГ-ын дүрэм	Чиг үүргийн давхардал	
		Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дүрэм	Бусад төрийн байгууллага
1	5.1.1.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насанд хүрэгчид, ахмад настны хөгжлийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдагдлаас сэргийлэх, бие даан амьдрах чадварт бэлтгэн өдрөөр хөгжүүлэх үйлчилгээг олон талт хэлбэрээр зохион байгуулах	5.7.6. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрах чадварт сургах, орон зайн чиг баримжаа олгоход чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, холбогдох чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;	Халамжийн байгууллагын үйлчилгээтэй ижил чиглэлтэй
2	5.1.2.1 Сэргээн засахын тусламж үйлчилгээ	5.6. Төв нь хүүхдийн сэргээн засах хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээний чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. 5.8.7 нөхөн сэргээх үйлчилгээ шаардлагатай ахмад настанд сэргээн засах үйлчилгээ үзүүлэх амьдралын хэв маягийн талаар (нойр, хооллолт, сэтгэл засал гэх мэт) зөвлөгөө өгөх, дасгал хөдөлгөөн заах, эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь төрийн эмнэлгийн үндсэн чиг үүрэг
3	5.1.2.2 Уламжлалт анагаах ухааны тусламж	-	Уламжлалт тусламжийг төрийн эмнэлгүүд (сувилал, уламжлалт эмнэлэг) үзүүлдэг
4	5.1.2.3 Сувиллын тусламж үйлчилгээ	-	Сувилал, нөхөн сэргээх тусламжийг төрийн салбар үзүүлдэг.
5	5.1.3.2 Сэтгэл зүйн зөвлөгөө (бүлгийн/гэр бүлийн/ганцаарчилсан)	5.8.1 гэр бүлийн болон ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө өгөх	НЭМ-ийн урьдчилан сэргийлэх, зөвлөх үйлчилгээ, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө үзүүлдэг
6	5.1.3.1 Олон нийтэд сургалт, нөлөөллийн соён гэгээрүүлэх ажил	5.8.2 эцэг эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүүхдээ дэмжих, насны онцлогт нийцүүлэн харилцан ойлголцох, эерэг аргаар хүмүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Эрүүл мэндийн боловсрол, нөлөөллийн сургалтыг төрийн байгууллагууд тогтмол зохион байгуулдаг.

7	5.1.1.3 Протез-ортопед, туслах хэрэгслийг тохируулах/зөвлөх/зарим засвар	5.7.4 Протез, ортопед, тусгай хэрэгсэл тохируулах, ашиглах зөвлөгөө өгөх, захиалга авах, зарим засвар үйлчилгээг үзүүлэх, бусад байгууллагуудад мэргэжил арга зүйн тусламж үзүүлэх	Төрийн эмнэлэг, сэргээн засах төвүүд ижил үйлчилгээ үзүүлдэг.
8	5.1.1.4 Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, холбон зуучлах	5.7.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэнд, амьдралын хэв маягийн талаар (нойр, хооллолт, сэтгэл хөдлөл гэх мэт) зөвлөгөө өгөх, холбон зуучлах, холбогдох асуудал хариуцсан төрийн болон мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах	Сургалт, зуучлал нь төрөөс хэрэгжүүлдэг тогтолцоотой
9	6.1.6 Нийгмийн халамжийн үйлчилгээ гэрээлэн гүйцэтгэх эрх бүхий магадлан итгэмжлэлийг авч, үйл ажиллагааг өргөжүүлж болно.	-	Халамжийн үндсэн үйлчилгээ төрийн мандаттай; гэрээлэн гүйцэтгэдэг
10	6.2.4 Төрийн болон төрийн бус байгууллагад мэргэжил-арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэргэжилтэн дадлагажуулах	6.2.5 өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын байгууллагад мэргэжил, арга зүйн лавлагаа тусламж, үзүүлэх холбогдох чиглэлийн мэргэжилтнийг богино хугацааны ажлын байранд дадгалжуулах, мэргэшүүлэх, төгсөлтийн дараах арга зүйн сургалт зохион байгуулах чиглэлээр тусгайлсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Арга зүйн чиглэлийн ажил, богино хугацааны дадлага нь төрийн байгууллагын чиг үүрэгтэй огтлолцоно.
11	6.2.7 Олон талт хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх	5.5 Төв нь төрийн болон төрийн бус байгууллагатай бүх түвшинд харилцан хүндлэлтэй хамтран ажиллана.	Хамтын ажиллагаа нь давхцал биш ч үр дүнгийн хэмжээнд функцийн давхцалыг уламжлах эрсдэлтэй.
12	1.5, 5.6 Даатгалын сонгон шалгаруулалтад хамрагдах хүртэл нэмэлт төлбөртэй тусламж үйлчилгээ		Даатгалын гэрээ байгуулдаг төрийн эмнэлгийн системтэй шууд огтлолцоно.

